

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
<b>Үүрэг, даалгавар ДӨРӨВ:</b> Он дуустал төсвийн орлого бүрдүүлэх ажлыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах.				
1	Төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх чиглэлээр өр барагдуулалтыг эрчимжүүлж, 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Хувь хүний орлогын албан татвар, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Галт зэвсгийн албан татвар, Газрын төлбөрийн төрлөөр нийт 5,651,731.7 мянган төгрөгийн өртэй 15785 татвар төлөгчдийн гар утсанд татвар төлөх тухай масс зурвасыг хүргүүлсэн. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг ханган татвар хураалтыг сайжруулах, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, татвар ногдуулах, төлөх, хүндрэл чирэгдлийг бууруулах зорилгоор татвар төлөгчдөд хуулийн хугацааг сануулсан постер, контентуудыг бэлтгэн, олон нийтийн сүлжээгээр түгээж байна. Дүүргийн төсвийн 2024 оны орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, төсвийн орлогын нэр төрөл бүрээр батлагдсан хуваарийн дагуу жигд ханган биелүүлэх, татварын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор шинээр үл хөдлөх эд хөрөнгө бүртгэх ажлыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу татварын өртэй иргэдэд нэхэмжлэх, мэдэгдэх хуудас, масс зурвасыг хүргүүлэх зэргээр хууль тогтоомжийн дагуу шат дараалсан ажиллагааг хийж, урьд оны болон тайлант оны өрийг барагдуулахаар ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Улсын төсөвт 95,532,301.0 төгрөг төвлөрүүлэхээс 90,555,606.0 төгрөг төвлөрүүлж 95%, нийслэлийн төсөвт 8,720,185.0 төгрөг төвлөрүүлэхээс 9,321,376.0 төгрөг давуулан төвлөрүүлж 107%, дүүргийн төсөвт 233,682,648.0 төгрөг төвлөрүүлэхээс 207,667,154.0 төгрөг төвлөрүүлж 89%-ийн биелэлттэй байна.	-	Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	90
<b>Үүрэг, даалгавар ТАВ:</b> Төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн жилд өр, авлага үүсгэлгүй, төсвийг зориулалтын зүйлд зарцуулж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах.				
2	Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын дагуу 78 байгууллагын бүлэг хоорондын болон сар хоорондын төсөвт зохицуулалт хийх тухай саналыг судлан, төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн жилд өр авлага үүсгэлгүй, зориулалт дагуу зарцуулж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхааран ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/32, А/45, А/121, А/171, А/193, А/231, А/332, А/334, А/378 дугаар захирамжаар төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж ажилласан.			100

<b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд мэдээллийн ил тод байдлыг хангаж, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд холбогдох хууль, журмын дагуу байршуулах ажлыг тогтмолжуулах.				
3	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим хуудсанд “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн тайланг улирал бүр нэгтгэн гаргаж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр үнэлгээ хийлгэн ажиллаж байна.			100
<b>Үүрэг, даалгавар ДОЛОО:</b> Нийслэлийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах.				
4	<p>Дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/366 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор Ажлын хэсэг байгуулж, нийт 15 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулж, баталсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлууд хийгдэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тусгаар тогтнолын талбайд сүлд мод засаж, мөсөн талбай, гэрлэн чимэглэлтэйгээр тохижуулах ажил, гүйцэтгэл 40%</li> <li>✓ Ж.Самбуугийн нэрэмжит гудамжийг гэрлэн чимэглэлтэйгээр тохижуулах ажил, гүйцэтгэл 45%</li> <li>✓ Дүүргийн Биеийн тамир, спортын хорооны хоккейн талбайг шинэ жилийн баярт зориулан тохижуулж, иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэх ажил, гүйцэтгэл 60%</li> <li>✓ Энхтайваны өргөн чөлөө, Бага тойруугийн гудамжинд байрших аж ахуйн нэгж, байгууллагуудын үүд, гадна талбайд гэрлэн чимэглэл хийлгэх ажил, гүйцэтгэл 40%</li> <li>✓ Тусгаар тогтнолын талбайн тохижуулсан хэсэгт тайз засаж, иргэд, олон нийтийг идэвхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх соёл, урлагийн арга хэмжээг өдөр бүр зохион байгуулах, гүйцэтгэл 30%</li> </ul>	-	Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор 15 үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллана.	70
<b>Үүрэг, даалгавар НАЙМ:</b> Нийтийг хамарсан баярын арга хэмжээний үеийн хэв журмыг сахиулах, бэлэн байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.				
5	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийг хамарсан баярын арга хэмжээний үеийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилгоор "DJI mavic 3 thermal" загварын дрон төхөөрөмжийг ашиглан хариуцсан нутаг дэвсгэрт өдөр бүр 6 төрлийн шторк, сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд, олон нийт ихээр цуглардаг зах, худалдааны төв, автобусны буудал орчимд цахим эргүүлийн үүрэг гүйцэтгэж байна. Мөн дүүргийн 4, 9-15 дугаар хороодод “Нийтийн эргүүл” арга хэмжээний хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, урамшуулалт эргүүл, иргэдтэй хамтран өдөр бүр 2-4 цагийн хугацаатай эргүүл, хяналт-шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. Шинэ жилийн баярын өдрийг тохиолдуулан архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад дүүргийн Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтсийн даргын 20240021-24 дугаартай албан шаардлага, 20240024 дугаартай мэдэгдлийг 237 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн. Дүүргийн нутаг	-	Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	70

	дэвсгэрт шинэ жилийн баярын арга хэмжээ зохион байгуулагдаж буй соёл урлаг, үзвэр үйлчилгээ, спортын арга хэмжээ зохион байгуулах болон нээлтийн арга хэмжээний үед ажиллах хүн хүчний тодотголыг хийж, бэлтгэл бэлэн байдлыг хангасан. Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтсээс 7 хоног бүрийн 5 дахь өдөр нэгдсэн эргүүлийг зохион байгуулж, дуудлага мэдээлэл ихээр бүртгэгдэж байгаа зах худалдааны төвүүдэд 09:00-17:00 цагийн хооронд 9 чиглэлд 18 алба хаагч явган эргүүлийн үүргийг тогтмол гүйцэтгэж байна.			
<b>Үүрэг, даалгавар ХОРИН ХОЁР:</b> Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.				
6	Дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг дэмжих зорилгоор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсгийн хурлыг долоо хоног бүрийн баасан гарагт тогтмол зохион байгуулж, ирүүлсэн хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сараас хойш хоол үйлдвэрлэлийн чиглэлээр 30, худалдааны чиглэлээр 28, нийт 58 хуулийн этгээдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгон ажилласан. Дүүргийн менежерийн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн "Тохилог-Чингэлтэй" аян зохион байгуулах тухай удирдамжийн дагуу 2024 оны 11 дүгээр сарны 01-ний өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрийг дуустал хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг болон согтууруулах ундаа, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтыг зохион байгуулж байна. Дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтэстэй хамтран дүүргийн 1-4 дүгээр хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй 100 аж ахуйн нэгж, байгууллагад 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар хяналт шалгалтыг зохион байгуулаад байна.	-	Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах чиглэлээр ажиллана.	70
<b>Үүрэг, даалгавар ХОРИН ГУРАВ:</b> Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд инженерийн хангамж, шугам тоноглолын найдвартай ажиллагааг хангаж, шуурхай ажиллах бригадыг бэлэн байлгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.				
7	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын "Хэрэглэгчдэд үйлчлэх төв-7" нь инженерийн шугам сүлжээний ажиллагаанд тогтмол хяналт тавин өдөр бүр халаалт, халуун хүйтэн усны мэдээ авч, гарсан зөрчлийг цаг алдалгүй шуурхай засварлан ажиллаж байна. Мөн нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын даргын 2024 оны А/251 дүгээр тушаал, "Хэрэглэгчдэд үйлчлэх төв-7" төвийн даргын 2024 оны А/17 дугаар тушаалын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хариуцлагатай эргүүл болон нэмэгдэл засварчдыг графикийн дагуу ажиллуулж байна.			100
<b>Үүрэг, даалгавар ХОРИН ДОЛОО:</b> Явган замын цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах.				
8	Нийслэлийн хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр орсон цаснаар Чингэлтэй дүүргийн хот, нийтийн аж ахуйн чиглэлээр ажиллаж буй "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК, "Найши трейд" ХХК-иуд бэлэн байдлын зэрэгт ажиллаж байна. Үүнд: Зам талбайн үйлчлэгч 135, жолооч 15, давс, бодис цацах тусгай зориулалтын 5 автомашин, экскаватор 1, автогрейдер 1, Ковш 2,			100

<p>зам талбайн шүүрдэгч тусгай зориулалтын автомашин 3, бобкат 2, бичил техник хэрэгсэл 4, нийт 18 техник хэрэгсэлтэйгээр хариуцсан авто замын нуух, явган хүний зам, хананаас хана хүртэлх цэвэрлэгээ үйлчилгээ болон тусгай зориулалтын давс бодисыг цацан ажилласан. Гэр хорооллын өгсүүр, уруу болон чулуун зам, төв зам, байшин хорооллын дундах авто замууд болох Ж.Самбуугийн гудамж, Баруун сэлбийн гудамж, Жуулчны гудамж, Их тойруу, Бага тойруу, Лааганы гудамж, Чингэлтэйн өргөн чөлөө, Хайлаастын авто замууд, Э.Галданбошигтын авто зам, Тасганы овооны авто зам, Хайлааст Чингэлтэйг холбосон авто зам, Зуслангийн замууд болох Жигжид, Яргайт, Яргайтын богино, Шадивлан, Гүнт зэрэг нийтийн эзэмшлийн 587592 м2 талбайн халтиргаа гулгааг арилган, давс, бодис цацаж ажилласан. Зам түрэх, хар цасыг арилгах ажлыг дээрх 2 байгууллага гүйцэтгэж, нийт 9 техник хэрэгслээр түрж тээвэрлэсэн ба 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1773 тонн бодис, 419 тонн давс, 505м3 дайрганы нөөцтэй байна.</p>			
<b>Үнэлгээний дундаж</b>			<b>87.5%</b>

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Ж.ЛХАГВАСҮРЭН

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ